

ЗАСАГ ДАРА

БАТЛАВ:

С.ГОНЧИГНЯМ

ӨВС ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

ТШ-ын код: ХӨАЦУСЗДТГ/20240202088]

ТШ-ын нэр: Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх

1. Барааны тодорхойлолт

- 1.1. 2024 оны намрын ургацаас бэлтгэсэн ногоон, цайвар ногоон өнгөтэй, өвсний өвөрмөц анхилам үнэртэй, гадны ямар нэг үнэргүй байх.
- 1.2. Өвс цайж хөхрөөгүй, харлаж борлоогүй, хөгцрөөгүй байх
- 1.3. Харлаж, хөгцөрсөн, ялзарч муудсан өвсийг сумын нөөцөд нийлүүлэхийг хориглоно.

№	Үзүүлэлтүүд	Хэмжээ
1	Сөөг, сөөгөнцөр ургамал /хувиас дээшгүй/	10
2	Хорт ба хөнөөлт ургамал /хувиас дээшгүй/	0.5
3	Хагд өвсний хэмжээ /хувиас дээшгүй/	15
4	Чийг /хувиас дээшгүй/	17
5	Нийт эслэг /хувиас дээшгүй/	28
6	Элс, шорооны хольц /хувиас дээшгүй/	0.5
7	Нийт протейн /хувиас доошгүй/	10
8	Каротины хэмжээ 1 кг-д /хувиас доошгүй/	20
9	Нэг боодол өвсний нягтрал /кг/ метр кубаас доошгүй	120
10	Нэг боодол өвсний хэмжээ /см/-ээр	50*30*80
11	Нэг боодол өвсний жин /кг/	20

1.4 Байгалийн болон таримал хадлан /өвс/-гийн ургамлын бүтээгдэхүүн нь стандарт /MNS 0592:2008 / үзүүлэлт, хүснэгтэнд заасан шаардлагыг хангасан байна.

1.5. Мал, амьтны гоц халдварт өвчингүй бүс нутгаас бэлтгэсэн байх

2. Баглаа боодол: MNS 0592:2008 улсын стандарт хангасан байна. Өвсний боодол задраагүй байх /шаардлага хангаагүй өвсийг хүлээн авахгүй/ машинаар тээвэрлэлт хийх тохиолдолд бороо, шорооноос хамгаалсан хучлагатай байх, зарлагын баримттай байх

3. Өвсийг цас, бороо, чийг ба асгаж үрэгдүүлэхээс хамгаалж, MNS5647:2006 стандартын дагуу тээвэрлэсэн байна.


4. **Бараа хүргэх газар:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төвд байрлах Сумын аюулгүйн нөөцийн агуулах

5. Цагаан-Уул сумын нөөцөд нийлүүлэх 40 000 000 төгрөгний 2759 боодол буюу 55.18 тонн өвсийг зориулалтын мяндсан утсаар боосон байх бөгөөд сумын аюулгүй нөөцийн агуулахад ачиж ирсэн өвсийг буулгаж хураах ажлыг тухайн гүйцэтгэгч компани мөн хариуцна.
6. Өвс нийлүүлэхдээ гарал үүслийн тодорхойлолт, стандартад тэнцсэн шинжилгээний дүнг дагуулан хүргүүлнэ.
7. Хүнс,хөдөө аж ахуйн газрын улсын байцаагчийн дүгнэлттэй байх / Лабораторын шинжилгээний дүнг хавсаргасан байна/
8. Бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичигт заасан дагуу ирүүлэх
9. Тендерт шалгарсан хуулийн этгээд нь барааг тээвэрлэх, ачих /сумын аюулгүй нөөцийн агуулахад буулгах/ болон татварын шимтгэлийг тендерийн үнэд багтаан тооцсон байх
10. Тендерт оролцогч хуулийн этгээд нь захиалагчид нийлүүлэх барааны дээж /1-2 боодол өвс/-ийг тендер нээхээс өмнө ирүүлсэн байх.

БОЛОВСРУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

 Н.АЛТАНБААТАР

ГИШҮҮН:  З.АЗЗАЯА

З.АЗЗАЯА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

 М.ОЮУНЧИМЭГ